

“ЭЛЭГ БҮТЭН МОНГОЛ” ҮНДЭСНИЙ ХӨТӨЛБӨРИЙН 2018 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

(2018 оны жилийн эцсийн байдлаар)

№	Хөтөлбөр/төслийн агуулга		Гүйцэтгэл
	Элэг бүтэн Монгол үндэсний хөтөлбөр, ЗГ-ын 2017 оны 112 дугаар тогтоол		Зорилго: Монгол улсын хүн амын дунд хепатит вирусийн халдварын тархалтыг хязгаарлан хепатит С вирусийн халдварын шинэ тохиолдлыг 2020 гэхэд таслан зогсоож, хепатитийн вирусээс үүдэлтэй элэгний архаг үрэвсэл, хатуурал, хорт хавдрын шалтгаант нас баралтыг эрс бууруулна.
2.	Санхүүжилтийн эх үүсвэр		Улс, орон нутгийн төсөв
3.	Хэрэгжүүлэгч байгууллага/хэрэгжих нийт хугацаа		Үндсэн хэрэгжүүлэгч байгууллага: СЭМТ, ӨЭМТ, СДЭ, ЭМГ, БОЭТ Хамтран хэрэгжүүлэгч байгууллага: АЗДТГ, СЗДТГ
4.	Төсөл, хөтөлбөрийн зорилтууд		Зорилт 1. Хүн амыг хепатитийн вирусийн халдвараас сэргийлэх, эрсдэлт зан үйлийг өөрчлөх, дархлаажуулалтыг өргөжүүлэх, мэдээллийн нэгдсэн цахим санг бүрдүүлэх замаар халдварын тандалт, хяналтын тогтолцоог бэхжүүлнэ. Зорилт 2. Үндэсний хэмжээнд хепатитийн вирусийн халдвар, элэгний хорт хавдрын эрт илрүүлэг, оношилгоо, эмчилгээний нотолгоонд тулгуурласан чанартай багц тусламж үйлчилгээг тэгш хүртээмжтэй үзүүлнэ. Зорилт 3. Хепатит вирусийн халдварын өвчлөл, элэгний хатуурал, хорт хавдрын оношилгоо, эмчилгээний эрдэм шинжилгээ, судалгааны ажлын тэргүүлэх чиглэлийг тодорхойлж, эмнэлзүйн тусламж, үйлчилгээнд нэвтрүүлнэ. Зорилт 4. Хепатитийн вирусийн халдвар, элэгний хорт хавдрын үед үзүүлэх эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэхэд төр, төрийн бус байгууллага, хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагын хамтын ажиллагааг нэмэгдүүлэх
5.	Зардал	Төсөв (нийт шаардагдах зардал)	

		дархлаажуулалтад хамрагдсан байна. Хөтөлбөр хэрэгжиж эхэлсэнээс хойш В вирусийн дархлаажуулалтын 3-н тунг бүрэн авсан нийт 1200 гаруй байна.
2-р зорилтын хүрээнд:	Хүрэх үр дүн 1: Үндэсний хэмжээнд хепатитийн вирусийн халдвар, элэгний хорт хавдрын эрт илрүүлэг, оношилгоо, эмчилгээний нотолгоонд тулгуурласан чанартай багц тусламж үйлчилгээг тэгш хүртээмжтэй үзүүлнэ	“Элэг бүтэн Монгол” хөтөлбөрийн хэрэгжилтийн 2-р шатны нээлт 2018 оны 3 сарын 28-ны өдөр амжилттай зохион байгуулж өндөрлөлөө. Нээлтэд Аймгийн Засаг дарга, удирдлагууд, Өрхийн эрүүл мэндийн төвүүд, Бүсийн оношилгоо эмчилгээний төв, Эрүүл мэндийн газар, бусад Аж ахуй нэгж байгууллагууд хамтран оролцлоо. Эрүүл мэндийн газраас нэгдсэн нээлтийн үйл ажиллагаанд 352,000. Сум өрхийн эрүүл мэндийн төвийн хөтөлбөрийн зардлаас нийтдээ 2,1070,00 төгрөг зарцуулагдсан байна. 2018 онд 50,0 сая төгрөгийн оношлуур, дагалдах хэрэгслийг нийлүүлсэн. Мэдээлэл сурталчилгааны материалд-3,000,000 сая төгрөг Даланзадгад сумын хэмжээнд нийтдээ 7 сургууль, 9 цэцэрлэг, 5 банк, төрийн байгууллага 12 эрүүл мэндийн байгууллага 8 хамрагдсан байн. Сумын түвшинд нийтдээ 14 сургууль, цэцэрлэг, 36 төрийн байгууллага, 12 хувийн хэвшлийн байгууллага хамрагдсан байна. Аймгийн хэмжээнд нийтдээ төрийн хувийн хэвшлийн 104 байгууллагын ажилчид хамрагдсан байна. Хувийн лаборатори 2 ажиллаж иргэдэд зөвлөгөө, мэдээллийн үйл ажиллагаа зохион байгуулсан. Эм ханган нийлүүлэх байгууллага, эмийн сан 3 оролцож эмийн хөнгөлөлт мэдээллийн үйл ажиллагааг зохион байгуулсан байна. БОЭТ нь мэргэжлийн эмчийн зөвлөгөөг иргэдэд хүргэж ажилласан байна. Эрүүл мэндийн даатгалын мэдээллийг мэргэжлийн хүмүүсээр дамжуулан иргэдэд хүргэсэн.
Санамж: Хүрэх гол үр дүнг бичнэ.		ХХЭМБ-28, Өрхийн эрүүл мэндийн төв- 22, Эрүүл мэндийн газар-5, БОЭТ-4, Эрүүл мэндийн даатгал-2, АСЗДТГазар-2 нийт 63 хүн мэдээлэл өгч ажилласан. Даланзадгад суманд 380, Бусад нийт сумдад- 1630 нийт- 2010 иргэн илрүүлэг шинжилгээнд хамрагдсан байна. 6 төрлийн 3600 ширхэг мэдээлэл сургалт сурталчилгааны зөвлөмжийг тараасан.Алтан говь ТВ-2 удаа, Өмнөговийн төв ТВ-1 удаа, Олон нийттэй харилцах албаар-2 удаа иргэдэд мэдээлэл хүргэгдсэн байна. Эмийн сангуудтай хамтран витаминжуулалтын арга хэмжээг зохион байгуулсан байна.

		Зорилтод насны иргэдийг АГ, чихрийн шижин, хөхний өмөнгийн эрт илрүүлэгт хамруулах, ЭХО оношилгоонд хамруулах ажлыг зохион байгуулсан байна. Мөн В вирусын сайн дурын дархлаажуулалтад нийт 155 иргэнийг эхний тунд хамруулсан байна. нээлтийн үйл ажиллагаа өргөн цар хүрээтэй зохион байгуулагдсан. Шинжилгээнд хамрагдалт: Аймгийн хэмжээнд 15-39 насны 9417, 40-65 насны 2070, 65-аас дээш насны 269 иргэн нийт 11756 иргэнийг шинжилгээнд бүрэн хамруулсан. Эдгээр иргэдийн мэдээллийг 2017 онд 40-65 насны иргэдийн мэдээллийг тусгай программд шивж оруулсан. 2018 онд 15-39 нас, 65-аас дээш насны иргэдийн мэдээллийг тусгай программд шивж оруулан мэдээллийн сан үүсгэн ажиллаж байгаа хэдий ч даатгалын төлөлт, баталгаажилт болон программын шинэчлэлтэй холбоотойгоор ипрограммд мэдээлэл бүрэн ороогүй байна. Вирусийн идэвхижил тодорхойлох шинжилгээ: хагас жилийн байдлаар вирус тоолуулах шинжилгээнд иргэдийн ийлдсийг хөлдөөн тээвэрлэдэг байсан бөгөөд идэвхжил тодорхойлох шинжилгээнд сорьц илгээсэн сумын эрүүл мэндийн төвөөс 323, Даланзадгад сумаас 438 хүний сорьц илгээгдсэн байна. Сорьц тээвэрлэх журам шинэчлэгдсэнээр одоогийн байдлаар ... шинжилгээнд хамрагдаад байна. Эмчилгээ: С вирусийн эмчилгээнд хамрагдсан 1100 иргэн эмчилгээнд хамрагдсан байна. С вирусийн эмчилгээнд хамрагдан вирус тэгэлсэн 500 гаруй иргэн байна. В вирусийн эмчилгээнд хамрагдаж буй 300 иргэн байна.
	3-р зорилтын хүрээнд: Хүрэх үр дүн 1: Хепатит вирусийн халдварын өвчлөл, элэгний хатуурал, хорт хавдрын оношилгоо, эмчилгээний эрдэм шинжилгээ, судалгааны ажлын тэргүүлэх чиглэлийг тодорхойлж, эмнэлзүйн тусламж, үйлчилгээнд	3-р зорилтын хүрээнд хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөний гүйцэтгэлийн тайлан

	нэвтрүүлнэ.	
	4-р зорилтын хүрээнд: Хүрэх үр дүн: 1 Хепатитийн вирусийн халдвар, элэгний хорт хавдрын үед үзүүлэх эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэхэд төр, төрийн бус байгууллага, хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагын хамтын ажиллагааг нэмэгдүүлэх	Хөтөлбөрийн 2017-2020 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг Аймгийн засаг даргаар батлуулан, 2018 оны үйл ажиллагааны календарчилсан төлөвлөгөөг Эрүүл мэндийн газрын даргаар батлуулан эрүүл мэндийн байгууллагыг зөвлөгөө зөвлөмжөөр хангаж ажилласан. Хөтөлбөрийн дагуу сум, өрхийн эрүүл мэндийн төвүүд нь эрүүл мэндийн салбар зөвлөлөөр төлөвлөгөөг болосвруулан, сарчилсан хуваарь төлөвлөгөө гарган ажилласан байна. Бид-Эрүүл мэндийг дэмжигч шилдэг байгууллага “Туг аялууллах” арга хэмжээ 14 сум, 23 агентлаг, төсөвт байгууллагаар аялуулж байна. Гашуун сухайтын хилийн боомтод ажиллан амьдарч буй иргэд, зорчигдыг үзлэг шинжилгээнд хамруулах арга хэмжээг зохион байгуулсан. Эрүүл мэндийн байгууллагуудын дунд болзолт уралдааныг зарлан ажиллаж байгаа бөгөөд 11-р сарын 20-оос тайлан мэдээг нэгтгэнэ. Мөн “Элэг бүтэн Өмнөговьчууд” орон нутгийн хөтөлбөрийн хүрээнд Ноён, Мандал-овоо, Сэврэй, Баян-овоо, Баяндалай сумын эрүүл мэндийн төвд халдварт болон халдварт бус өвчнөөс урьдчилан сэргийлэх, эрт илрүүлгийн үйл ажиллагааг сайжруулах зорилгоор мобайл тоног төхөөрөмжийн багцаар хангасан. Бүсийн оношилгоо эмчилгээний төвд үзлэгт шаардлагатай эм, урвалжийн нөөцийг хангасан. 14 сумын ЭМТөв, 4 өрхийн ЭМТ-ийн эрт илрүүлгийн үйл ажиллагаанд 12 сая төгрөгний дэмжлэг үзүүлсэн. Нийгмийн даатгалтай хамтран ажилласан байдал, санхүүжилт: Эрүүл мэнд нийгмийн даатгалын мэргэжилтэнтэй хамтран 2 удаагийн хурал, цахим теле сургалтад хамтран оролцсон. Даатгалын талаарх мэдээллийг тогтмол хүргэн ажиллаж байна. Даатгалын сангаас С вирусийн эмэн эмчилгээнд 86,560,000 төгрөгийн санхүүжилт хийгдсэн байна. 40-65 насны илрүүлэг шинжилгээний санхүүжилт эхний 10 хувь болох 5,480,000 төгрөг, дараагийн санхүүжилт 13,000,000 санхүүжилтийг даатгалын сангаас авсан байна. Энэ нь нийт авах ёстой санхүүжилтийн 70%-ыг авсан байна. Элэг бүтэн Өмнөговьчууд аймгийн хөтөлбөр: Аймгийн иргэдийн төлөөлөгчдийн тэргүүлэгчдийн 52 дугаар тогтоолоор “Элэг бүтэн Өмнөговьчууд” хөтөлбөрийг батлан

		гаргасан. Энэхүү хөтөлбөрийн хүрээнд 2018 онд 95,000,000 төгрөгийг төсөвлөн гаргасан бөгөөд хөтөлбөрийн санхүүжилтын 50%-г тоног төхөөрөмжинд, 12%-г эрүүл мэндийн байгууллагуудад, 26%-г сургалт сурталчилгаанд, 12%-г эм урвалжинд зарцуулаад байна. хөтөлбөрийн төсвийн зарцуулалт 90%-тай байна. үлдэгдэл санхүүжилтыг “Хавдрын эсрэг хамтдаа 2018” аяныг зохион байгуулахад зарцуулахаар бэлтгэл ажил хангагдаад байна.
7.	Дүгнэлт (ололт, дутагдал, анхаарах асуудлууд)	Давуу тал: Хөтөлбөрийг хэрэгжүүлснээр элэгний өвчлөлийг эрт илрүүлэх, хяналтад авч өвчлөл, нас баралтыг бууруулах боломжтой юм. Мөн иргэдийн эрүүл мэнддээ хүлээх үүрэг хариуцлага нэмэгдэж байна. Улсын хэмжээнд халдварт бус өвчний эрт илрүүлгийн үйл ажиллагааг идэвхижүүлэх нэг арга зам болж байгаа бөгөөд айман орон нутгийн төсвөөр сумын эрүүл мэндийн төвд мобайл технологийн хэрэглээг өргөтгөж байгаа нь бусад аймгуудаас давуу талтай байна. Хөтөлбөр орон нутгийн дэмжлэгтэйгээр хэрэгжиж байна. Мөн хөтөлбөрийн хүрээнд Өмнөновь аймгийн хэмжээнд 2018 оны хорт хавдрын шалтгаант нас баралт 31 бүртгэгдсэнээс 18 тохиолдол нь элэгний хорт хавдар байсан бөгөөд энэ нь өмнөх онтой харьцуудлахад хорт хавдрын шалтгаант нас баралт 6-р, элэгний хорт хавдраар нас баралт мөн 6-р буурсан үзүүлэлттэй байгаа нь цаашид буурах хандлагатай байгааг харуулж байна. Сул тал: Вирус илэрсэн иргэд тоолуулах шинжилгээнд хамрагдахын тулд хөдөө орон нутгаас аймгийн төврүү ирж шинжилгээнд хамрагдах нь алслагдсан сум орон нутгийн иргэдэд хүндрэлтэй байна. Мөн элэгний вирусийн эм бичих эрхтэй эмч аймгийн хэмжээнд 2 эмч байгаагаас нэг нь урт хугацааны чөлөө авсан, нөгөө нь тэтгэврийн насны эмч ачаалал ихтэй ажиллаж байна. Эдгээр асуудлыг шийдэхийн тулд Эрүүл мэндийн яамруу эм бичих эрхтэй эмчийн тоог нэмэгдүүлж өгөх албан бичгийг хүргүүлсэн. ЭМЯ “Элэг бүтэн Монгол” хөтөлбөрийн ажлын хэсгээс сургалтыг дахин зохион байгуулах шийдвэр гарсны дагуу сургалтад нийт 12 эмчийг сургахаар мэдээллийг хүргүүлсэн. Сүүлийн хагас жилд хөтөлбөрийн программ шинэчлэлийн асуудлаас шалтгаалан программд шивэгдсэн иргэдийн үзүүлэлт бага байна. Үүний шалтгаан нь цахим

			программын сургалт албан хаагчдын амралтын улиралд хийгдсэн тул зохих мэргэжлийн эмч нар буюу дүн бүртгэгч нар бүрэн хамрагдаж чадаагүй. Энэ асуудлыг шийдвэрлэх үүднээс ЭМЯ-руу сургалтыг дахин зохион байгуулах хүсэлтийг тавьсан. Өрхийн эрүүл мэндийн төвийн санхүүжилт хангалтгүй байдаг учир энэ нь тэдний ажил ачааллыг нэмэгдүүлж байна. Цаашид анхаарах асуудал: - Өрх, сумын эрүүл мэндийн төвд үйл ажиллагааны санхүүжилтийг нэмэлтээр олгох - Эмчилгээ бичдэг эмч нарын тоог нэмэгдүүлэх сургалтыг яаралтай зохион байгуулах - Илрүүлэг шинжилгээний багцад аюулгүй хайрцаг, бээлий, хөвөн спиртийг нэмэх - МСС материал болон бичиг хэргийн тодорхой зардлыг шийдэх - В вирусийн сайн дурын вакцины хангалтыг нэмэгдүүлж, тасалдалгүй байдлыг хангах										
8.	Төсөл, хөтөлбөрийг хэрэгжүүлэгч талуудын хамтын ажиллагаанд өгөх хөндлөнгийн үнэлгээ		Захиалагч талууд, хэрэгжүүлэгч талууд, санхүүжүүлэгч тал, гүйцэтгэгч талууд хэрхэн хамтарч ажилласан талаар энд бичнэ.										
9.	Төсөл, хөтөлбөрийн хэрэгжилтийн үнэлгээ, дүгнэлт (өөрийн үнэлгээ)	Биелэлт дундаж	Зорилтын тоо	Зорилт 1	Зорилт 2	Зорилт 3	Зорилт 4						
		... %	4	95 %	95%	... %	95%						
10.	Төсөл, хөтөлбөрийн хэрэгжилтийн нэгдсэн үнэлгээ (ЗГХЭГ-ын үнэлгээ)		Нэгдсэн үнэлгээ										
			... %										

Хэрэгжилт гаргасан..... /албан тушаалтан/

Хянасан /албан тушаалтан/